

ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХЭД¹ ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ц.ГАНЧИМЭГ

*ДХИС-ийн ОБС-ийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн
дэд профессор, хошууч, докторант*

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гамшгийн давтамж, эрчим нэмэгдэж тогтвортой хөгжилд саад учруулж, бүх улс орны ард иргэд гамшигт өртөх байдал нь эмзэг байдал буурахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгож, гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байгааг тоо, баримтууд харуулж байна.

Дэлхийд өнгөрсөн жилийн хугацаанд гамшгийн улмаас олон хүний амь нас үрэгдэж, хүн ам, олон нийт, улс орны аюулгүй байдал, сайн сайхан аж байдалд сөргөөр нөлөөлжээ. Нийтдээ 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн, 23 сая орчим хүн орон гэргүй болж, гамшигт 1.5 гаруй тэрбум хүн ямар нэгэн байдлаар нэрвэгджээ. Мөн хүүхэд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн иргэд харилцан адилгүй өртсөн байна.

Тэр дундаа гамшиг осолд өртөж буй нийт хүн амын 30 гаруй хувийг хүүхэд эзэлж байна². Иймд гамшгийн үе дэх хүүхэд хамгааллын асуудал, бусад салбарын оролцоог хангасан цогц үйлчилгээг хөгжүүлэх асуудлыг улс орон бүр бодлогын түвшиндээ авч үзэж байна.

Аливаа гамшиг, онцгой байдлын үед дараах 4 бүлэг хүмүүс эрсдэлд өртөх хамгийн их магадлалтай байдаг.

- хүйс (эмэгтэйчүүд, жирэмсэн эхчүүд)
- нас (хүүхэд, хөгшид)
- үндэстэн ястан эсвэл нийгмийн давхарга (ядуурал, жуулчид)
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Энэ дотроос хамгийн их хохирол амсдаг бүлэг нь хүүхдүүд юм³.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог хангаж гамшгийн аюулаас өөрийгөө сэргийлэх дархлаа суулгах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх боловсролыг эзэмшүүлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг дадалтай болгоход хүүхдийг оролцуулах нь үр дүнтэй болохыг олон улсын туршлага харуулсаар байна.

Гэвч өдөр бүр хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн дэлхий ертөнцөд гамшиг тохиолдсон үед хүүхэд ямар аюул, эрсдэлт өртөмтгий байна вэ? Эдгээр эрсдэлээс хүүхдээ хэрхэн хамгаалж, тайван цагт ч, гамшиг, онцгой байдлын үед ч эрүүл аюулгүй өсөн бойжих орчныг нь бүрдүүлэх вэ? гэсэн асуултын хариулт байсаар байна.

Монгол Улсын “Хүүхдийн эрхийн тухай” хуулинд хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх талаар, “Хүүхэд хамгааллын тухай” хуулинд хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу үйлчилгээ үзүүлэх талаар тусгагдсан байдаг. Манай улсад 2018 оны байдлаар 18 хүртэлх насны 1.125⁴ мянга гаруй хүүхэд байгаа нь нийт хүн амын 35.3 хувийг эзэлж байна.

Хүүхэд бол бусдын адил гэр бүлдээ өсч хүмүүжих, хөгжих, боловсролд хамрагдах, халамж, хамгаалал шаардлагатай хүн амын эмзэг бүлэг. Хүүхэд нь нас, сэтгэхүй, оюун ухаан, амьдралын онцлог байдлын улмаас хүчирхийлэл, дарамт,

мөлжлөг, үл хайхрах байдалд өртөх эрсдэлтэй байдаг.


НҮБ, бусад олон улсын байгууллага болон хүүхэд хамгааллын салбар нь бүх хүүхэд бие бялдар, сэтгэц, сэтгэл зүй, насны онцлогоосоо хамааран дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлын золиос болох эрсдэлд байна гэж үздэг. Түүний дотор зарим хүүхэд хүйс, яс үндэс, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, эцэг эхийн халамж асрамж, аж байдал зэрэг хүчин зүйлсээс болж аливаа сөрөг хүчин зүйлд өртөх эрсдэл илүү өндөр, хүнд нөхцөлд амьдарч байна.

Тоон мэдээллийн өнөөгийн байдал

Манай улсад 2018 оны байдлаар 18 хүртэлх насны 1.125⁵ мянга гаруй хүүхэд байгаа нь нийт хүн амын 35.3 хувийг эзэлж байна. 18 хүртэлх насны нийт хүүхдийн 44.7 хувь буюу 503.4 мянга нь Улаанбаатар хотод амьдарч байгаа бөгөөд тэдний 48.8 хувь нь эмэгтэй хүүхдүүд байна.

Зураг 1. Нийслэлийн хэмжээнд буй 18 хүртэлх насны хүүхэд, дүүргээр

Хэмжих нэгж: хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийслэлийн нийт хүүхдийн 23.6 хувь нь Баянзүрх дүүрэгт, 22.5 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 15.6 хувь нь Баянгол дүүрэгт байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Хүн амын тоо болон хүн амын төвлөрлөөс шалтгаалан Налайх, Багануур, Багахангай дүүрэгт 18 хүртэлх насны хүүхэд хамгийн бага хувийг эзэлж байна. Нийслэлийн нийт хүүхдүүдийн 36.2 хувийг 0-4 настай, 32.9 хувийг 5-9 настай, 20.9 хувийг 10-14 настай, 10.0 хувийг 15-17 настай хүүхдүүд эзэлж байна.

Хүснэгт 1. Нийслэлийн хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, байршлаар


Хэмжих нэгж: тоо

	0-4 нас		5-9 нас		10-14 нас		15-17 нас	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Багануур	1683	1549	1634	1643	1163	1156	641	564
Багахангай	265	268	246	244	206	164	84	90
Баянгол	15212	14277	13341	12771	8124	7798	3610	3524
Баянзүрх	21944	20888	19986	19303	12797	12160	6076	5866
Налайх	2232	2165	2301	2229	1565	1480	833	787
Сонгинохайрхан	20934	19932	19137	18024	12062	11683	5871	5654
Сүхбаатар	8866	8212	8322	7952	5386	5097	2677	2422
Хан-Уул	12605	12194	10917	10472	6704	6461	3011	2917
Чингэлтэй	9676	9114	8749	8505	5800	5567	2897	2782
Нийт дүн	93417	88599	84633	81143	53807	51566	25700	24606

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өнөөдөр хүүхдэд олон зүйлийн эрсдэл учирч байна. Үүнээс шалтгаалан хүүхэд хамгааллын болон нийгмийн ажлын олон хариу үйлчилгээнүүд шаардлагатай болж байна. Нийслэлийн статистикийн газрын 2018 оны мэдээгээр нийслэлийн хэмжээнд бүтэн өнчин 1399 хүүхэд, хагас өнчин 11676 хүүхэд байна.

Зураг 2. Хагас өнчин, бүтэн өнчин хүүхэд, дүүргээр



Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар,

Нийслэлийн хэмжээнд буй нийт бүтэн өнчин хүүхдийн 26.2 хувь нь Баянзүрх, 24.7 хувь нь Сонгинохайрхан, 11.5 хувь нь Хан-Уул дүүрэгт байна. Хагас өнчин хүүхдүүдийн 60.1 хувь нь мөн дээрх 3 дүүрэгт амьдарч байна.

Дүүргүүдийн нийт хүүхдийн тоонд өнчин хүүхдийн эзлэх хувийг авч үзвэл Багахангай дүүргийн нийт хүүхдийн 5.3 хувь нь, Багануур дүүргийн хүүхдүүдийн 4.5 хувь нь, Налайх дүүргийн хүүхдүүдийн 4.2 хувь нь өнчин хүүхэд байгаагаас харахад нь алслагдмал 3 дүүрэгт өнчин хүүхдийн эзлэх хувь өндөр байна. Гамшгийн үед хамгийн их хохирол амсдаг нийгмийн бүлэг бол хүүхэд байдаг.

Гамшиг осолд өртсөн хүүхэд


Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ. Ахуйн осол гэдэг нь санамсар болгоомжгүй болон бусад үйл ажиллагааны улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирохыг хэлнэ. Дээрх нөхцөл байдалд өртсөн хүүхдийг гамшиг осолд өртсөн хүүхэд гэнэ.

Манай орны хувьд түгээмэл тохиолддог болон тохиолдож болох осол гамшгийн төрлүүд гэвэл объектын болон ой хээрийн түймэр, зам тээврийн осол, хүчтэй цасан болон шороон шуурга, үер, аянга цахилгаан, хүн малын гоц халдварт өвчин, химийн хорт бодис, хий алдагдах, асгарах, тэсрэх дэлбэрэх бодисын аюул, газар хөдлөлт гэх мэт олон гамшиг осол байдаг бөгөөд үүнд олон хүүхэд өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирсон судалгаанууд байна

ОБЕГ-ын мэдээгээр 2018 онд нийслэлийн хэмжээнд аюулт үзэгдэл, осолд өртсөн 2-10 насны нийт 7 хүүхэд байгаагийн 3 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй хүүхэд байна. Харин аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан нийт 18 хүүхэд байна.

Зураг 3. Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан шалтгаан, 2018 он

Хэмжих нэгж: хувь



Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар

Нас баралтын шалтгааныг харвал тэдний 55.5 хувь нь галд өртөж, 27.8 хувь нь усанд живж, 11.1 хувь нь осгож, 5.6 хувь нь цахилгаанд цохиулан нас баржээ.

2019 онд нийслэлийн хэмжээнд аюулт үзэгдэл, осолд өртсөн хүүхдийн судалгаанаас харахад эхний хагас жилд нийт 24 хүүхэд аюулт үзэгдэл, осолд өртсөн байна. Үүнээс 17 хүүхэд объектын гал түймрийн улмаас галд өртсөн бол үлдсэн 7 хүүхэд нь ахуйн осолд өртжээ.

2019 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн хэмжээнд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан 1-13 насны нийт 4 хүүхэд байна. Тэдний 2 нь гал түймэрт өртөж, 2 нь усанд живж нас баржээ. Энэ мэтчилэн аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүүхдүүдийн дийлэнх нь ахуйн ослын улмаас нас барсан нь эцэг, эх, асран хамгаалагчаас хүүхдэд тавих анхаарал болгоомж, хараа хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн дийлэнх нь гэр бүлийн орчинд эрсдэлт өртөж байна. Гамшиг, онцгой байдлын үед хүүхдэд учирдаг аюул, эрсдэлүүдэд бие махбодын хохирол, нийгэм сэтгэл зүйн хямрал, гэр бүлээсээ хагацах, тусгаарлагдах, мөлжлөг болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх зэргээс гадна хүүхдийн эмзэг байдлыг дараах хүчин зүйлүүд нэмэгдүүлдэг гэж үзэж болно.

- Хүүхэд нас, биеийн хөгжлөөс шалтгаалж эцэг эхээсээ маш их, зарим үед бүрэн хамааралтай байх

- Тэдний өдрийн хуваарь өрхийн доторх насан хүрэгчид ялангуяа эхийнхээ ажилтай нягт холбогддог

- Хүүхдүүд гамшгийн тухай мэдлэгтэй байсан ч туршлага дутах явдал түгээмэл байдаг.

- Хоол тэжээлийн хомсдол
- Агаар, усны бохирдол
- Бие махбодын хохирол
- Сэтгэл санааны хохирол
- Орон байрны хомсдол
- Ядуурал

Хоол тэжээлийн хомсдол

Бага, өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, өсөлтөд ноцтой нөлөөлнө. Жирэмсэн эхчүүдийн эрүүл мэнд, үр хөврөлд муугаар нөлөөлж, төрөх хүүхдийн жин багасах, өлөн, хоол муутай эх хүүхдээ хөхөөр нь зөв хооллох боломжгүй учраас нярай хүүхдийн эрүүл

мэндийг эрсдэлтэй болгодог. Ерөнхийдөө гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн уургийн дутагдал, тэжээлийн хомсдолд нэрвэгдэх явдал түгээмэл байдаг.

Монгол Улсад хүнс, хүнсний шимт тэжээл болон гамшгийн хяналт, хариу үйлдлийн системийг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл зохицуулдаг ба хүнсний баталгаат бус байдлын үндсэн шалтгаан нь ялангуяа байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр үүсэх зуд, ган түүнээс үүсэх ядуурал юм.⁶

Онцгой байдлын байгууллага нь түргэн явцтай гамшиг (газар хөдлөл, гал түймэр), удаан явцтай гамшиг (зуд, ган, үер)-т хариу үйлдэл үзүүлэх чадавхаа дээшлүүлж байгаа хэдий ч гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, хариу үйлдлийг сайжруулахдаа эмзэг бүлгийн хүн амын гамшигт илүү их нэрвэгддэг учраас хүнсний баталгаат байдалтай холбоотой мэдээллийг тусгайлан авч үзэх нь чухал юм.

Агаар, усны бохирдол

Хүүхдүүд пестицид, хар тугалга, улаан мөнгөн ус, зэрэг бохирдуулагч бодисуудыг биеийн жинд харьцуулахад ихээр шингээж авдаг учраас маш эмзэг байдаг. Агаар, усны бохирдол гамшиг, онцгой байдлын дараа түгээмэл тархдаг тул үүнээс үүсдэг халдварт өвчний гол нэрвэгдэгч нь хүүхдүүд болдог.

Бие махбодын хохирол

Хүүхдийн өөрийгөө хамгаалах чадвар сул дорой байдаг тул болзошгүй гамшгийн үед нэрвэгдэх магадлалыг ихэсгэн амь насаа алдах, гэмтэж бэртэх явдал ихсэх хандлагатай байдаг. Үүнд тэдний бичиг, үсэг, боловсролын байдал ч нөлөөлдөг.

Сэтгэл санааны хохирол

Гамшиг онцгой байдлын үед эцэг, эх, ойр дотныхоо хүнийг алдах, тэднээс тусгаарлагдах, дарамт хүчирхийлэлд өртөх зэргээр тэдний авсан сэтгэлийн шарх хамгийн хүнд хохирол болдог бөгөөд маш удаан хугацаанд үргэлжилдгээрээ онцлог. Энэ үед нөхөн сэргээх арга хэмжээ авах нь юу юунаас чухал байдаг.

Хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцаанд оролцуулах ажил нь гамшгийн байдлыг даван туулахад чухал бөгөөд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын үндсэн үйлчилгээ болно. Онцгой нөхцөл байдал үүсэн үед хүүхэд янз бүрийн үйлдэл үзүүлдэг⁷.

- Ж нь: Зарим хүүхэд үүссэн нөхцөлийг хүндээр тусгаж авч байхад зарим нь харьцангуй хөнгөн, нөгөө хэсэг нь ямар ч хариу үйлдэлгүй хэвийн байдаг.

- Ихэнх хүүхдийн бие, сэтгэл, нийгмийн суурь хэрэгцээ нь хэсэг зуур хямарч байсны долоо хоног, сарын дараа эргээд хэвийн байдалдаа ордог.

Орон байрны хомсдол

Үүссэн нөхцөл байдлын улмаас орон гэргүй болсон хүүхдүүд нүүлгэн шилжүүлсэн хорогдох байранд ахуйн хэрэглээний наад захын шаардлага хангахгүй орчинд тогтохгүй тэнүүчлэх, янз бүрийн дарамт шахалтад (үндэстэн, ястан, шашин, нийгмийн давхарга, хүйс гэх мэт) орох явдал ихэсч тэр хэрээр тэдний эмзэг байдал нэмэгддэг.

Ядуурал

Амьжиргаа нь гамшиг, онцгой байдлын улмаас сүйрсэн ядуу айл өрхүүд орлого олуулахаар хүүхдээ сургуулиас гаргах, ажил хийлгэх явдал түгээмэл тохиолддог. Гамшгийн дараа хомсдлын улмаас хүүхдүүд хүнд хүчир хөдөлмөр эрхлэх, боолчлогдох, жендерээс үүдэлтэй бэлгийн хүчирхийлэлд өртөх, хил дамнуулан худалдагдах зэргээс гэмт хэргийн золиос болох нь элбэг болж өсөх хандлага ажиглагддаг байна.

Эрсдэлийн шалтгааныг арилгах, эрсдэл тохиолдоход учирч болох хор уршгийг бууруулах нэг хүчин зүйл нь гамшгийн үед тэдний эрхийг хамгаалах явдал юм.

Гамшиг, онцгой байдлын үед нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцаанд оролцуулах ажил нь гамшгийн байдлыг даван туулахад хэрэгтэй бөгөөд гамшгийн үеийн эзмэг бүлгийн иргэдийн хамгааллын үндсэн үйлчилгээг

онцгой анхаарах шаардлагатай. Учир нь нийгмийн эмзэг бүлгийн иргэд асран хамгаалах, хагалзан дэмжих хүнгүй, өөрөө өөртөө туслах боломжгүй, хөдөлгөөн хязгаарлагдмал, хэлж ойлгуулах, тусламж хүсэх чадвар хомс байдгаас **эмзэг бүлэгт** багтдаг.

Гамшгийн үед нийгмийн эмзэг бүлгийг хамгаалахтай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгийг судлан үзвэл нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч тэдний нийгмийн хамгааллыг бий болгохтой холбоотой дараах зохицуулалтууд байна. Тухайлбал,

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ 1989 он
- Ерөнхий Асамблейн 1992 оны 10-р сарын 16-ны өдрийн №475 тогтоол, “Насжилтын талаарх тунхаглал”
- Саламанкагийн тунхаглал 1994 он
- Дакарын үйл ажиллагааны хүрээ “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он
- “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал)” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2001 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан бичиг баримт” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2004 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, НҮБ 2006 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын Удирдамж” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консорциум 2010 он⁸
- НҮБ-ын 64 дүгээр ассамблейн A/RES/64/131 тогтоол⁹
- “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк 2011 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал” 2012 он
- Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012 он
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22-р зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн халамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс төрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй” гэж заасан нь бүх нийтийн эрхийг хангасан заалт юм. Мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын “оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтаар баталгаажна.

1994 оны ЮНЕСКО-гийн Саламанкагийн мэдэгдэлд “Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн гарал, сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа болон бусад нөхцөл байдлыг үл харгалзан хүүхэд бүрийг авч сургах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд

болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Тэгш хамруулах боловсрол нь бүх хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн сурах хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд энэхүү үзэл баримтлал нь 1990 оны Бүх нийтийн боловсролын дэлхийн бага хурал болон Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх Саламанкагийн мэдэгдлийн суурь болж Дакарын боловсролын форумар дахин баталгаажсан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж, Нэгдсэн Үндэстний ард түмэн дүрэмдээ хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэд итгэдгээ нотолж, нийгмийн дэвшлийг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэхэд илүү эрх чөлөөтэйгөөр дэмжлэг үзүүлэх саналтай байгааг анхаарч; Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүүхэд онцгой халамж, туслалцаа авах эрхтэй гэж тунхагласныг санаж, гэр бүл, түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстойг ойлгож, аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөж бойжих нь хүүхдийн бүрэн, өв тэгш хөгжлийг хангах болохыг хүлээн зөвшөөрч, хүүхдэд ийм онцгой халамж тавих шаардлага байгаа тухай Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын тунхаглал, Ерөнхий Ассамблейгаас 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тунхаглал болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /тухайлбал 23, 24 дүгээр зүйлүүд/, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт /тухайлбал 10 дугаар зүйл/, түүнчлэн хүүхдийн аж байдлын асуудал эрхэлсэн олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын холбогдох баримт бичиг, дүрэмд тусгагдаж хүлээн зөвшөөрснийг анхааралдаа авч энэхүү конвенцыг баталсан. Уг конвенцын 3 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч буюу түүний төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн эрх, үүргийг харгалзан, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээг авна” хэмээн заасан.

Дүгнэлт

Нийт хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдүүдийг нийгмийн бүх орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага.

Мөн гамшгийн янз бүрийн үе шатанд болон тайван цагт гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, аврах хүч хэрэгсэл, удирдлагын шуурхай үйл ажиллагааг бүх түвшинд хангахдаа гамшгийн үед илүү өртөх магадлалтай, өөрийгөө аюул ослоос хамгаалах чадваргүй эсвэл асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүн буюу өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд зэргийг хамааруулан тэднийг хамгаалахад тохирсон бодлого, төлөвлөлт боловсруулах шаардлага байна

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Үндсэн хууль 1992 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
3. Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он

5. Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 он
7. Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
8. Боловсролын багц хууль 2002 он
9. Барилгын тухай хууль 2016 он
10. Эрүүл мэндийн тухай хууль 2011 он
11. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
12. Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
13. Ахмад настны тухай хууль 2017 он
14. Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он
15. www.Legalinfo.mn, www.nso.mn
16. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого үйл ажиллагаа"-77-р тал
17. Ц.Давхарбаяр, Г.Жаргал, "Нийгмийн хамгааллын эрх зүй", УБ 2010 он. 7-11-р тал
18. Р.Ганбат, Р.Жаргалмаа,"Онцгой байдлын үед дэхь хүүхэд хамгааллын гарын авлага" УБ 2017 он 56-р тал
19. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Төрийн мэдээлэл сэтгүүл, 2016, №9
20. Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал судалгааны тайлан 10 дахь тал